# "Мандал Даатгал" ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлан

| | | |
|---|---|---|
| **Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/** | | |
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | | |
| ***Тайлагнах хугацаа*** | | *2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр* |
| ***Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар*** | | *Мандал даатгал ХК, 000172636, MSE:MNDL, 7575-2000* |
| **Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр** | | *Монголын хөрөнгийн бирж* |
| **Бизнесийн үйл ажиллагааны салбар** | | *Ердийн даатгал* |
| **Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо** | | *ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК, 2015-01-21* |
| **Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг** | | *624,301,600* |
| **Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр** | | |
| **1** | ***Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*** | |
| | ***Санхүүгийн байдлын үзүүлэлт*** | Тайланг хавсаргав |
| | ***Орлогын тайлан*** | Тайланг хавсаргав |
| | ***Өмчийн өөрчлөлтийн тайлан*** | Тайланг хавсаргав |
| | ***Мөнгөн гүйлгээний тайлан*** | Тайланг хавсаргав |
| **1.1** | ***Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт*** | |
| | Аудитын дүгнэлт хавсаргав. | |
| ***1.2.*** | ***Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү заавартдурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/*** | |
| | Аудитын дүгнэлт хавсаргав. | |
| **2** | ***Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл*** | |
| ***2.1.*** | ***Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/*** | *Нийт хөрөнгийн өгөөж (ROA): 10%* |
| | | *Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 22%* |
| ***2.2.*** | ***Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт*** | *Төлбөрийн чадварын харьцаа: 144%* |
| ***2.3.*** | ***Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл*** | *2021 оны байдлаар нийт хөрөнгө, мөнгөн хөрөнгийн үзүүлэлтээр салбартаа тэргүүлж, нийт хураамжийн орлогын хэмжээгээр зах зээлд 15%-г эзэлж байна.<br>-Нөхөн төлбөрийн хурдыг нэмэгдүүлэх зорилгоор цахим нөхөн төлбөрийн хэсэг гаргаж, тохиолдлын дуудлагыг шуурхай дуудлагын зохицуулагч авч ~5 хувийг цахим баримтжуулдаг байсныг нөхөн төлбөрийн мэргэжилтэн дуудлага авдаг болсноор ~46 хувийг цахим баримтжуулж, шуурхай шийддэг болоод байна.<br>-2021 онд доорх бүтээгдэхүүнийг шинээр зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд мөн дижитал сувгаар буюу mandal.mn сайтаар борлуулж эхэлсэн.<br>oPRIUS даатгал<br>oСедан даатгал<br>o4x4 даатгал<br>oХүүхдийн даатгал* |
| ***2.4.*** | ***Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/*** | *Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй* |
| ***2.5.*** | ***Тайлант хугацаанд авсан зээлийн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл*** | *2021 онд авсан зээл байхгүй* |
| ***3*** | ***Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/*** | |
| | *Сонирхлын зөрчилтэй хэлцэл байхгүй* | |
| ***4*** | ***Цалин урамшууллын мэдээлэл*** | |
| | *Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат, хараат бус гишүүдэд 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан төсвийн дагуу цалин урамшуулал олгосон.* | |
| ***5*** | ***Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*** | |
| | *Компанийн бүтцийн хувьд Маркетинг, Бизнес хөгжлийн газрын бүтэц өөрчлөгдөн Бизнес хөгжил, андеррайтингийн газар болон Маркетингийн газар болж өөрчлөгдөв.<br>ТУЗ гишүүд тус оны 4 дүгээр сарын 19-ны хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдсон.<br>•ТУЗ ердийн гишүүн - Ө. Ганзориг, Ш. Гантуяа, О. Ганжолоо, О. Мөнхжаргал, Л. Ганзоригт, Б. Жавхлан<br>•ТУЗ хараат бус гишүүн - Жэймс Бернард Двайер, Ж. Дэлгэрсайхан, Г. Гантулга<br>•Компанийн гүйцэтгэх захирал Ч. Даваадаш* | |
| ***6*** | ***Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл*** | |
| | *Байхгүй* | |
| ***7*** | ***Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/*** | |
| | *Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөлт ороогүй.<br>2022 оны 04 сарын 04-ний өдрийн байдлаарх нөлөө бүхий хувьцаа эзэмшигч<br>1 . Голомт Файнэншил Групп ХХК - 255,000,000 - 40.85%<br>2. Юу Эм Си Капитал ХХК - 233,864,016 - 37.46%<br>3 . Олон нийт - 135,437,584 - 21.69%* | |
| ***8*** | ***Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхлэснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл*** | |
| | *2021 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй* | |
| ***9*** | ***Ногдол ашгийн мэдээлэл*** | |
| | *2021 онд өмнөх оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 3 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан ба 2021 оны 6-р сарын 2-ны өдөр "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан.<br>2021 оны цэвэр ашгаас нийт 1,872,904,800 төгрөг буюу нэгж хувьцаанд 3 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн байна.* | |
| ***10*** | ***Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл*** | |
| | *Нийгэмд чиглэсэн контентоор дамжуулан брендийн хоногшуулалт бий болгох зорилгоор бага насны хүүхдүүдэд багаас нь эрсдэлийн боловсрол олгох зорилготой онлайн сургуулийг байгуулан нийтлэг тохиолддог 9 видео хичээл гаргаж нийт 11,350 бүртгэлтэй гишүүнтэй болсон байна. Мөн иргэдэд эрүүл мэндийн баталгаатай, эх сурвалжтай мэдээллийг хүргэх, иргэдийн эрүүл мэндийн мэдлэг боловсролтой болох зорилгоор eDoctor.mn төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж эрүүл мэндийн контентуудыг хийн байршуулсан.* | |

PKF

Accountants & business advisers

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Даун Таун Бьюлдинг, #602 тоот,
Жамъяан гүний гудамж -18/1,
1 -р хороо, Сүхбаатар дүүрэг-14240,
Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976-75057979
Факс: +976-70186131

Имэйл: info@pkf.mn

Ref:13/MD/02/12032021/BP

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## “МАНДАЛ ДААТГАЛ” ХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

---

### Дүгнэлт

Бид "МАНДАЛ ДААТГАЛ" ХК (цаашид “Компани” гэх) –ийн 2021 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2021 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

### Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

### Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй.

**Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС - ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцооллууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэвч ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

**Бусад зүйл**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

| | |
|---|---|
| П.БАЯРМАА | ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК |
| Гүйцэтгэх захирал | Мэргэшсэн нягтлан бодогчид |

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2022 оны 3 дугаар сарын 14

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

## АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2020; 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

| | Тодруулга | 2020 онд (төгрөгөөр) | 2021 онд (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| **Даатгалын үйл ажиллагаа** | | | |
| Даатгалын хураамжийн нийт орлого | | 33,224,744,322 | 35,614,682,559 |
| Даатгалын хураамжийн буцаалт (-) | | (1,599,998,199) | (1,217,596,438) |
| Давхар даатгалын хураамжийн зардал (-) | | (15,220,697,315) | (15,730,123,355) |
| **Даатгалын хураамжийн цэвэр орлого (2+3+4)** | | **16,404,048,808** | **18,666,962,766** |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт (+, -) | | 8,537,039,518 | (3,573,794,005) |
| Хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт (+,-) | | (9,140,560,166) | 3,221,319,464 |
| **Орлогод тооцсон хураамж (5-6-7)** | | **17,007,569,456** | **19,019,437,307** |
| Нийт нөхөн төлбөрийн зардал | | 7,862,275,196 | 8,150,304,062 |
| Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр (+) | | 640,961,516 | 1,132,089,182 |
| Буруутай этгээдээс авах нөхөн төлбөр (+) | | 57,144,178 | 161,533,403 |
| **Нөхөн төлбөрийн цэвэр зардал (9-10-11)** | | **7,164,169,502** | **6,856,681,478** |
| Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн өөрчлөлт (+, -) | | 985,026,403 | 302,849,461 |
| Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт (+, -) | | (634,774,134) | 457,609,484 |
| Учирч болзошгүй хохирлын нөөцийн сангийн өөрчлөлт (+,-) | | 842,617,584 | 318,044,069 |
| **Зардалд тооцсон нөхөн төлбөр (12+13+14+15)** | | **8,357,039,354** | **7,935,184,491** |
| Даатгалын гэрээний зардал (-) | | (1,541,835,730) | (1,858,376,263) |
| Давхар даатгалын шимтгэлийн орлого (+) | | 127,739,695 | 207,256,940 |
| Хөрөнгө оруулалтын орлого (+) | | 4,788,911,770 | 5,009,598,756 |
| **Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал) (8-16+17+18+19)** | | **12,025,345,837** | **14,442,732,250** |
| Эрхийн шимтгэлийн орлого (+) | | 29,564,589 | 10,389,588 |
| Бусад орлого (+) | | 344,952,809 | 97,129,488 |
| Ерөнхий ба удирдлагын зардал (-) | | (6,600,522,936) | (7,269,853,263) |
| Борлуулалт, маркетингийн зардал (-) | | (940,020,591) | (937,145,506) |
| Санхүүгийн зардал (-) | | (254,691,450) | (100,294,497) |
| Бусад зардал (-) | | (417,553,854) | (40,094,152) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) (+, -) | | 824,659,685 | 80,098,800 |
| Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) (+, -) | | 0 | 18,838,942 |
| **Бусад ашиг (алдагдал) (20+21+…+29)** | | **(7,013,611,748)** | **(8,140,930,600)** |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) (20+30)** | | **5,011,734,089** | **6,301,801,651** |
| Орлогын татварын зардал | | 477,665,930 | 693,810,729 |
| **Татварын дараах ашиг (алдагдал) (31-32)** | | **4,534,068,159** | **5,607,990,921** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) (+,-) | | 0 | 0 |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) (33+34)** | | **4,534,068,159** | **5,607,990,921** |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | 0 | 0 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | (76,052,176) | 1,334,439,928 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | 0 | 0 |
| Бусад | | 0 | 0 |
| **Орлогын нийт дүн (35+36+37)** | | **4,458,015,983** | **6,942,430,849** |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | | | |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2020; 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ

| | Тодруулга | 2020.12.31 (төгрөгөөр) | 2021.12.31 (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө | | 2,652,209 | 3,867,629 |
| Харилцахад байгаа мөнгө | | 2,227,681,692 | 3,715,658,675 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн** | | **2,230,333,901** | **3,719,526,305** |
| **Даатгалын авлага** | | | |
| Даатгалын хураамжийн авлага | | 5,047,245,855 | 6,830,235,147 |
| Буруутай этгээдээс авах авлага | | 165,558,658 | 146,689,341 |
| Давхар даатгалаас авах авлага | | 43,970,188 | 529,155,504 |
| **Даатгалын авлагын дүн** | | **5,256,774,700** | **7,506,079,992** |
| **Бусад санхүүгийн хөрөнгө** | | | |
| Бусад авлага | | 369,608,496 | 41,641,127 |
| **Бусад санхүүгийн хөрөнгийн дүн** | | **369,608,496** | **41,641,127** |
| **Бусад санхүүгийн бус хөрөнгө** | | | |
| НДШ -ийн авлага, бусад татварын авлага | | 9,975,498 | 447,750 |
| Бараа материал | | 37,363,639 | 142,781,949 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | 519,920,011 | 746,569,342 |
| **Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн** | | **567,259,148** | **889,799,041** |
| **Хөрөнгө оруулалт** | | | |
| Хадгаламж, хадгаламжийн сертификат | | 24,819,086,976 | 510,313,008 |
| Үнэт цаас | | 6,536,362,519 | 34,079,903,906 |
| **Хөрөнгө оруулалтын дүн** | | **31,355,449,496** | **34,590,216,914** |
| **Даатгалын хөрөнгө** | | | |
| Хойшлогдсон давхар даатгалын хураамж | | 12,264,733,685 | 9,043,414,221 |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг | | 767,863,598 | 310,254,114 |
| Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал | | 716,141,226 | 996,001,397 |
| **Даатгалын хөрөнгийн дүн** | | **13,748,738,509** | **10,349,669,733** |
| **Үндсэн хөрөнгө /Цэвэр/** | | **1,487,975,832** | **1,300,408,836** |
| **Биет бус хөрөнгө /Цэвэр/** | | **139,596,239** | **261,972,444** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **55,155,736,321** | **58,659,314,392** |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /үргэлжлэл/

2020; 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ

| | Тодруулга | 2020.12.31 (төгрөгөөр) | 2021.12.31 (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| **Даатгалын өглөг** | | | |
| Даатгалын хураамжийн буцаалтын өглөг | | 31,095,643 | 132,929,788 |
| Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг | | 88,720,829 | 212,901,117 |
| Давхар даатгагчид өгөх өглөг | | 2,799,160,785 | 3,778,539,793 |
| **Даатгалын өглөгийн дүн** | | **2,918,977,257** | **4,124,370,697** |
| **Бусад санхүүгийн өр төлбөр** | | | |
| Санхүүгийн түрээсийн өр төлбөр | | 497,905,000 | 193,672,222 |
| Ногдол ашгийн өглөг | | 19,073,518 | 19,073,518 |
| **Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн** | | **516,978,518** | **212,745,740** |
| **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | | | |
| Цалингийн өглөг | | 289,088,812 | 169,500,000 |
| НДШ-ийн өглөг | | 10,372,687 | 1,359,419 |
| ААНОАТатварын өглөг | | 121,133,795 | 130,670,048 |
| ХХОАТатварын өглөг | | 18,830,916 | 96,046,882 |
| Урьдчилж орсон орлого | | 331,502,845 | 774,068,002 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | | 501,817,896 | 552,520,692 |
| **Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн** | | **1,272,746,952** | **1,724,165,044** |
| **Орлогод тооцоогүй хураамжийн нөөц** | | **21,371,085,493** | **17,797,291,488** |
| **Нөхөн төлбөрийн нөөц сан** | | | |
| Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан | | 2,489,888,288 | 2,062,732,279 |
| Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан | | 1,640,011,855 | 2,370,017,324 |
| Учирч болзошгүй хохирлын нөөц сан | | 1,035,567,204 | 1,353,611,273 |
| Тусгай нөөц сан | | 1,256,290,011 | 1,256,290,011 |
| **Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн** | | **6,421,757,358** | **7,042,650,888** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | | **32,501,545,579** | **30,901,223,857** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Эзэмшигчдийн өмч | | 6,243,016,000 | 6,243,016,000 |
| Нэмж төлөгдсөн капитал | | 4,441,895,708 | 4,441,895,708 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | (147,148,582) | 1,187,291,346 |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | | 12,116,427,616 | 15,885,887,480 |
| **ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | **22,654,190,743** | **27,758,090,535** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | **55,155,736,321** | **58,659,314,392** |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

## ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

| (төгрөгөөр) | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **6,243,016,000** | **4,441,895,708** | **(71,096,406)** | **10,115,433,874** | **20,729,249,177** |
| Залруулсан үлдэгдэл | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | **6,243,016,000** | **4,441,895,708** | **(71,096,406)** | **10,115,433,874** | **20,729,249,177** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 4,534,068,159 | 4,534,068,159 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | (125,709,321) | | (125,709,321) |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | (35,868,016) | (35,868,018) |
| Зарласан ногдол ашиг | | | | (2,497,206,400) | (2,497,206,400) |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | 49,657,145 | | 49,657,145 |
| **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **6,243,016,000** | **4,441,895,708** | **(147,148,582)** | **12,116,427,616** | **22,654,190,743** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 34,373,742 | 34,373,742 |
| Залруулсан үлдэгдэл | **6,243,016,000** | **4,441,895,708** | **(147,148,582)** | **12,150,801,358** | **22,688,564,484** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 5,607,990,921 | 5,607,990,921 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | 1,334,439,928 | | 1,334,439,928 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | (1,872,904,800) | (1,872,904,800) |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | |
| **2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **6,243,016,000** | **4,441,895,708** | **1,187,291,346** | **15,885,887,480** | **27,758,090,535** |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

| | 2020 (төгрөгөөр) | 2021 (төгрөгөөр) |
|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **33,191,584,116** | **34,958,697,834** |
| Даатгалын хураамжийн орлого | 31,390,135,053 | 32,595,227,512 |
| Давхар даатгалын нөхөн төлбөр | 929,033,649 | 616,820,193 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 1,421,100 | 0 |
| Бусад мөнгөн орлого | 870,994,314 | 1,746,650,129 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **29,935,749,548** | **32,204,432,632** |
| Ажиллагчдад төлсөн | 3,438,296,291 | 3,434,664,004 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 361,600,000 | 885,080,000 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 35,764,000 | 346,474,243 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 20,878,942 | 92,355,551 |
| Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж | 13,976,367,804 | 13,788,467,850 |
| Нөхөн төлбөрт төлсөн | 7,505,806,578 | 8,170,210,060 |
| Үүнээс: Сайн дурын даатгалын | 7,066,336,239 | 7,248,406,998 |
| Албан журмын даатгалын | 439,470,339 | 921,803,062 |
| Даатгалын төлөөлөгчийн шимтгэл | 179,476,496 | 347,228,672 |
| Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр | 835,086,096 | 903,026,514 |
| Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр | 2,830,000 | |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 51,031,064 | 76,550,879 |
| Хүүний төлбөрт төлсөн | 254,691,450 | |
| Татварын байгууллагад төлсөн | 779,584,927 | 1,384,055,806 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 238,224 | 2,931,660 |
| Бусад мөнгөн зарлага | 2,494,097,677 | 2,773,387,393 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **3,255,834,567** | **2,754,265,202** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **44,946,332,449** | **69,901,733,199** |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 42,558,794,061 | 65,696,053,967 |
| Хүлээн авсан хүүний орлого | 2,287,227,601 | 4,105,490,150 |
| Хүлээн авсан ногдол ашиг | 100,310,786 | 100,189,082 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **44,498,685,845** | **69,266,452,358** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 459,822,777 | 398,412,681 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 265,812,696 | 110,782,751 |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 43,773,050,371 | 68,757,256,926 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **447,646,604** | **635,280,841** |
| **САНХҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **5,119,684,549** | **(52,075)** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 5,100,000,000 | 0 |
| Валютын ханшийн зөрүү | 19,684,549 | (52,075) |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **7,496,969,003** | **1,900,301,565** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 5,100,000,000 | |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 153,622,114 | 203,974,269 |
| Төлсөн ногдол ашиг | 2,243,346,889 | 1,696,327,296 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(2,377,284,454)** | **(1,900,353,640)** |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 1,326,196,718 | 1,489,192,404 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **904,137,183** | **2,230,333,901** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **2,230,333,901** | **3,719,526,305** |

*Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*